



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/263

Хэрлэн сум

Улсын уралдаанд  
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 15 дугаар хуралдааны 06 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.6.3 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор “Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн нэрт бүжиг дэглээч Д.Санжаасүрэнгийн нэрэмжит зүүн монголын уламжлалт, шинэ үеийн мэргэжлийн гоцлол, цөөхүүл бүжигчид, ерөнхий боловсролын сургуулийн шилдэг бүжгийн хамтлаг шалгаруулах улсын уралдаан”-д 20,000,000 (хорин сая) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2. Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Тус зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх “Хэнтийн түүх - бидэнд чухал” арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023 оны  
04 дугаар сарын 27-ны өдрийн  
А/263 дугаар захирамжийн хавсралт

Монгол Улсын Урлагийн Гавьяат Зүтгэлтэн нэрт бүжиг дэглээч  
Д.Санжаасүрэнгийн нэрэмжит нэрэмжит ЕБС-ийн шилдэг бүжгийн хамтлаг,  
мэргэжлийн гоцлол, цөөхүүл бүжигчдийн Улсын анхдугаар уралдаант  
наадмын зардлын тооцоо.

№	Байр эзэлхүүн	Мөнгөн дүн
1	Шагналын зардал /ЕБС-ийн шилдэг хамтлаг/	4,300,000
2	Шагналын зардал /Мэргэжлийн цөөхүүл бүжигчид/	4,900,000
3	Шагналын зардал /Мэргэжлийн гоцлол бүжигчин/	3,700,000
4	Шагналын зардал /Шилдэг хөгжмийн зохиолч/	1,000,000
5	Шагналын зардал /Шилдэг бүжиг дэглээч/	1,000,000
6	Шагналын зардал /Шилдэг уран бүтээл, шилдэг бүжигчид/ Гран при	3,000,000
7	Шүүгчдийн зардал	2,100,000
Нийт дүн		20,000,000